



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/773

Ховд

Гэрээ цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.4, 56 дугаар зүйлийн 56.2, 56.3, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2.4, 4.6, 4.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөст, Цэцэг, Дуут сумдын агнуурын бүс нутгийн менежментийг хариуцах хамтын ажиллагааны 2016 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан гэрээг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон цуцалсугай.

2. Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцах хамтын ажиллагааны гэрээг цуцалсантай холбогдуулан тус гэрээг сум тус бүрээр, хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулж, батлахыг Дуут сумын Засаг дарга /С.Ганзориг/, Мөст сумын Засаг дарга /Б.Баасандорж/, Цэцэг сумын Засаг дарга /Ж.Мөнхзориг/, нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ